

Түүх 10: Иаков 2
(Иаков Бетелд)

Библийн эшлэл
[Эхлэл 28:15]

Харагтун, Би чамтай хамт байж, хаана ч явсан чамайг хамгаалан,
чамайг дагуулж, энэ нутагт буцааж авчирна.
Би чамд амласнаа биелүүлэх хүртэл чамайг орхихгүй гэж айлджээ.

Иаков, ахынхаа ууган хүүгийн эрх болон ерөөлийг мэхлэн авснаасаа болж ахдаа үзэн ядагджээ.

Тэр ахаасаа холдон зугтаж, хол замд гарахаас өөр аргагүй байв. Нагац ах Лабаных тэднийхээс их хол амьдардаг байжээ.

Иаковын сэтгэл ихэд түгшин сандарч байв. Хав харанхуй шөнө болж, Иаков чулуу дэрлэн хээр талд унтахаар хэвтэв.

Тэгтэл Иаков нэгэн зүүд зүүдэлжээ.

Зүүдэнд нь, газар дээр нэгэн шат босож, түүний орой нь тэнгэрт тулан, бас дахин харвал, түүгээр Бурханы тэнгэр элч нар өгсөн уруудан байлаа. Гэтэл Бурхан түүний дээр зогсоод ингэж хэлэв.

“Иаков! Би бол Эзэн. Чиний хэвтэж байгаа газрыг Би чамд болон чиний үр удамд өгнө. Чиний үр удам энэ газрын шороо шиг олон болж, чи хаана ч байсан Би чамайг хамгаалан, чамайг дагуулах бөгөөд чамайг орхихгүй.” гэв.

Иаков босонгуутаа дэрлэж байсан чулуугаа аван, Бурханд талархал өргөөд тэр газрыг Бетел гэж нэрлэжээ.

Иаков яван явсаар нагац ахындаа иржээ. Иаков нагац ах Лабаны охин Рахелд анхны харцаар дурлав. Тэгээд тэр Лабанд хандан, “Ах минь, бага охин Рахелаа надтай гэрлүүлээч. Оронд нь долоон жилийн турш танд зарцлагдъя” гэв.

Цаг хугацаа өнгөрсөөр нэг л мэдэхэд долоон жил өнгөрчээ.

Тэр Рахелд маш их хайртай байсан учир долоон жил нүд ирмэхийн зуур адил мэдрэгджээ.

Гэвч Лабан Рахелыг биш түүний том эгч Леаг түүнтэй гэрлүүлэв.

Лабан Иаковт хандан ингэж хэлжээ. “Чи үүний төлөө дахин долоон жилийг гүйцээ. Тэгээд би чамд Рахел охиноо өгье”

Иаков түүний үгэнд итгэн дахин долоон жил хичээнгүйлэн ажиллав.

Арай хийж 7 жил өнгөрөв. Ингээд хайртай Рахелтайгаа гэрлэжээ.

Иаков Леа болон Рахелтай гэрлэн олон хүүхэдтэй болов.

Ийнхүү Бурханы ерөөлөөр Иаков хөрөнгө чинээтэй нэгэн болжээ.



Бүтээлч байцгаая 1. **Доорх асуултад хариулаарай.**

а. Есав, дүү Иаковдаа яагаад өшөө хорсол тээж байсан бэ?

б. Иаков хаашаа зугтсан бэ?

с. Иаков ямар зүүд зүүдэлсэн бэ?

● **Дараах библийн эшлэлийг уншаад цээжлээрэй (Эхлэл 28:15)**

Би чамтай хамт байж, хаана ч явсан чамайг хамгаалан







Нэп :